

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨМА-2022/42/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.umnugovi@audit.gov.mn Өмнөговь аймаг 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 88034203 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 88025452 Цахим хаяг: jargale@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

МАНДАЛ-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Э.АДЪЯАСҮРЭН ТАНАА

2022.02.23 № 137
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал-овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мандал-овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд 5,759,360 төгрөгийн үндсэн хөрөнгө, 37,920,394 төгрөгийн бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй, аж ахуйн материал болон бичиг хэргийн зардлын зарцуулалтын тайлан гаргахдаа 10,757,836 төгрөгийн шаардах хуудас бөглөөгүй, бараа үйлчилгээний бусад зардлаас үндсэн хөрөнгө болон цалин хөлс, хоолны зардалд зарцуулсан зөрчлүүд нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, санхүүгийн тайлангийн толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх, ангилал гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0100000000

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink, appearing to read 'S. Tserenbayar', is written over a faint red rectangular stamp.

С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	16.9	93.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,465.8	1,484.1
	Нийт хөрөнгийн дүн	1,482.7	1,577.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,482.7	1,577.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,482.7	1,577.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	469.8	708.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	456.5	605.6
	Үйл ажиллагааны үр дүн	13.3	102.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	46.3	9.9
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(33.0)	92.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1.9	1.9
	Тайлант оны үр дүн	92.6	92.6
	Эцсийн үлдэгдэл	1,118.1	1,577.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	379.5	534.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	379.0	526.1
	Үйл ажиллагааны ЦМГ	0.5	8.7
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0.5	0.4
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	8.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	394.1	381.7
	Урсгал зардал	394.1	381.3
	Хөрөнгийн зардал	-	0.4
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	394.1	390.0
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	343.4	343.4
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34.6	34.6
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16.1	11.8
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	0.2

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал-овоо сумын Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө тусламж үйлчилгээ үзүүлэх" гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал,

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

Тайлант онд бараа үйлчилгээний зардлаас үндсэн хөрөнгө болон цалин хөлс, хоолны зардал гарган зарцуулсан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Мандал-овоо сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мандал-овоо сумын Эрүүл мэндийн төв нь

- Шилэн дансны нэгдсэн системд 149 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан
- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа ажил үйлчилгээний 200.0 сая төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй,
- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 17 гүйлгээ буюу 95.9 сая төгрөгийн, зарлагын 13 гүйлгээ буюу 116.7 сая төгрөгийг мэдээлээгүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-г мөрдөж ажиллаагүй төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Иймд дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн анхаарч үзэх шаардлагатай гэж үзэв.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 498.0 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 30.9 сая төгрөгийн алдааг залруулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 албан шаардлага өгсөн.

4.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дансны үлдэгдлийг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад 5.7 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн тооллого хийж, тооцоог бодоогүй байна.

Өгсөн албан шаардлага:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1 " үндсэн хөрөнгө , дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/" заасныг хэрэгжүүлэн ажиллах

2.Илрүүлэлт:

Аж ахуйн материал болон бичиг хэргийн зардлын зарцуулалтын тайлан гаргахдаа 8.8 сая төгрөгийн материалын зарцуулалтын шаардах хуудсыг бөглөөгүй, түлш шатах материалын 10 дугаар сарын 1.9 сая төгрөгийн зарцуулалтын шаардах хуудсыг байгууллагын дарга гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Өгсөн албан шаардлага:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах

3.Илрүүлэлт:

Бараа материалын тодруулга тайлангийн дансны үлдэгдлийг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад 37.9 сая төгрөгийн бараа материалын тооллого хийж, тооцоог бодоогүй байна.

Өгсөн албан шаардлага:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2 " түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэснийг хэрэгжүүлэн ажиллах

4.Илрүүлэлт:

Тайлант онд бараа үйлчилгээний зардлаас үндсэн хөрөнгө болон цалин хөлс, хоолны зардал гарган зарцуулсан байна.

Өгсөн албан шаардлага:

Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах

5.Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн системд 149 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 17 гүйлгээ буюу 95.8 сая төгрөгийн, зарлагын 13 гүйлгээ буюу 116.7 сая төгрөгийг мэдээлээгүй, 5 сая

төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа ажил үйлчилгээний 200.0 сая төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй байна.

Өгсөн албан шаардлага:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4" таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр мэдээлнэ " гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

Аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	12	85,3	8	30,9	0	0	1	54,4	0	0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	12	85,3	8	30,9	0	0	1	54,4	0	0

/сая төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	3	412,7	0	0	0	0	1	412,7	0	0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	3	412,7	0	0	0	0	1	412,7	0	0
	НИЙТ ДҮН	15	498,0	8	30,9	0	0	2	467,1	0	0